



# ЭРЭЭНЦАВ ХК

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр  
сарын 25-ны өдөр

ТУЗ-04/2025

Улаанбаатар  
хот

### Эрэнцав ХК-ийн 2024 оны Үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах, 2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1, 76-р зүйлийн 76.1-р заалт болон Эрэнцав ХК-ийн дүрмийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны Үйл ажиллагааны тайлан болон Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг 1-р хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2-р хавсралтаар баталсугай.
3. Батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Ц.ЛХАГВАДОРЖ



# ЭРЭЭНЦАВ ХК

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 дугаар  
сарын 25-ний өдөр

ТУЗ-05/2025

Улаанбаатар  
ХОТ

### 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлт болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загварыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.11, 96-р зүйлийн 96.5, 96.6, 71-р зүйлийн 71.3-р заалтууд<sup>1</sup>, Эрээнцав ХК-ийн дүрэм, ТУЗ-ийн 2025.02.10-ны өдрийн ТУЗ-01/2024 тоот тогтоол, Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-иас ирүүлсэн “Эрээнцав ХК-ийн 2024.12.31-ны өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлангийн аудитын тайлан”-г тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Эрээнцав ХК-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг 1-р хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, батлуулахыг Гүйцэтгэх захирал М.Батад даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн 2025.04.25-ны өдрийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлаар санал авах Саналын хуудасны агуулга, загваруудыг 2-р хавсралтаар баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн 2025.04.25-ны өдрийн хуралд батлагдсан саналын хуудасны загвараар санал авахыг Тоологын комиссын дарга Л.Даваад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:





2025 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

ТУЗ-03/2025

Улаанбаатар  
хот

### Эрээнцав ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.4, 60-р зүйлийн 60.1, 60.2, 62-р зүйлийн 62.1, 76-р зүйлийн 76.1-р заалтууд, Эрээнцав ХК-ийн дүрмийг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 16:00 цагт хуралдуулсугай.
- Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.2-ын дагуу дараах мэдээллийг баталсугай.
  - Хурал хуралдах газар:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот Эрхэт трейд ХХК-ийн байранд;
  - Хуралдах өдөр, цаг:** 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 16:00 цагт;
  - Хурлаар хэлэлцэх асуудлууд:** 2024 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах; 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах; ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг дуусгавар болгох; ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох; Бусад;
  - Бүртгэлийн өдөр:** 2025 оны 03-р сарын 01-ний өдөр;
  - Хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр:** 2025 оны 02-р сарын 12, 2025 оны 02-р сарын 27-ны өдөр;
  - Хурлын дарга:** Ц.Лхагвадорж /ТУЗ-ийн дарга/
  - Тооллогын комиссын дарга, гишүүд** Дарга: Л.Даваа, Гишүүд: Г.Одгэрэл, Л.Ням
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, холбогдох баримт бичгийг 2025.02.11-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.
- Хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах комиссыг Ц.Лхагвадорж /комиссын дарга/, Л.Даваа, М.Бат нарын бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.4-т заасны дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэл, компанийн цахим хуудас, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2025.02.12, 2025.02.27-ны өдрүүдэд олон нийт, хувьцаа эзэмшигчидэд хүргэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдлийг 1-р хавсралтаар баталсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн танилцах Баримт бичгийн жагсаалтыг 2-р хавсралтаар баталсугай.

8. Хурлын тухай олон нийтэд мэдээлэх зарын загварыг 3-р хавсралтаар баталсугай.
9. Компанийн Аудитын бодлогын баримт бичгийн 1.2, 9.1-р заалтууд, Компанийн засаглалын кодексийн 2024 оны тайлангийн 16-р заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулах хөндлөнгийн аудиторыг сонгож ажиллахыг Аудитын хороо /Н.Баярсайхан/-нд даалгасугай.
10. Хуралтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг ТУЗ-ийн дарга /Ц.Лхагвадорж/-д зөвшөөрсүгэй.
11. Энэхүү шийдвэрийг олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Ц.ЛХАГВАДОРЖ

Эрэнцав ХК-ийн ТУЗ-ийн 2025.02.10-ны өдрийн  
ТУЗ-03/2025 тоот тогтоолын 1-р хавсралт

Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдэл

Компанийн нэр	Эрэнцав ХК
Компанийн хаяг, байршил	Дорнод аймаг, Чулуунхороот сум, 2-р баг 01 тоот Утас: 99102280
Хурал хуралдах өдөр, цаг	2025.04.25-ны өдрийн 16:00 цагт
Хурал хуралдах газрын хаяг, байршил	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот, Эрхэт трейд ХХК-ийн байр
Хурлын төрөл	Ээлжит хурал
Хурал зарлагч	Төлөөлөн удирдах зөвлөл
Хуралдах шийдвэр гаргасан огноо	2025.02.10-ны өдрийн ТУЗ-ийн шийдвэр
Олон нийтэд зарлах огноо	2025.02.12, 2025.02.27-ны өдрүүд
Бүртгэлийн өдөр	2025.03.01-ний өдөр
Хурлын баримт бичгийг брокерийн компанид хүргүүлэх огноо	--
Хурлын даргын нэр	Ц.Лхагвадорж /ТУЗ-ийн дарга/
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Комиссын дарга: Л.Даваа Гишүүд: Г.Одгэрэл, Л.Ням
Баримт бичгийн жагсаалт /хавсралт/	Тогтоолын 2-р хавсралтаар баталсан
Баримт бичгийн хуудасны тоо	Нийт 33 хуудас

Хурал зохион байгуулах комиссын дарга:

  
Ц.ЛХАГВАДОРЖ

ЭРЭЭН ЦАВ  
ХК  
2025.02.10-ны өдөр



# ЭРЭЭНЦАВ ХК

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

ТУЗ-02/2025

Улаанбаатар  
хот

### Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1, 46-р зүйлийн 46.1, 46.6, 76-р зүйлийн 76.1.12-р заалтууд болон Эрэнцав ХК-ийн дүрмийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

- 2024 оны санхүүгийн жилд үйл ажиллагаа тогтворгүй байснаас шалтгаалан компани ашиггүй ажилласан тул компанийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдсүгэй.
- Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй тухай үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах, үйл ажиллагааны тайланд тусгахыг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Ц.ЛХАГВАДОРЖ